



**ЦАХИМ (БИОМЕТРИЙН) ДИПЛОМАТ ПАСПОРТ ЭЗЭМШИГЧДИЙГ
ВИЗИЙН ШААРДЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ ЭСТОНИ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Эстони Улсын Засгийн газар, цаашид "Хэлэлцэн тохиролцогч талууд" гэх.

Хоёр улсын хоорондын найрсаг харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхийг эрмэлзэн,

Хэлэлцэн тохиролцогч талуудын цахим (биометрийн) дипломат паспорт эзэмшигч иргэдийг хоёр улсын хооронд харилцан зорчихыг хөхиулэн дэмжиж, үг нөхцөлийг хөнгөвчлөхийг зорьж,

Хоёр улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон,

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

1. Хүчин төгөлдөр цахим (биометрийн) дипломат паспорттой Монгол Улсын иргэд Бүгд Найрамдах Эстони Улсын нутаг дэвсгэрт нэвтрэн орсноос хойш нэг зуун наян (180) хоногийн хугацаанд ер (90)-ээс дээшгүй хоног визгүйгээр нэвтрэн орох, гарах, дамжин өнгөрөх болон зорчих эрхтэй бөгөөд тэдгээр нь Бүгд Найрамдах Эстони Улсад хувиараа хөдөлмөр эрхлэх, эсхүл өөр аливаа бусад бизнесийн үйл ажиллагаа явуулах зэрэг аливаа хэлбэрийн хөдөлмөр эрхлэхийг хориглоно.

2. Хүчин төгөлдөр цахим (биометрийн) дипломат паспорттой Бүгд Найрамдах Эстони Улсын иргэд Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрэн орсноос хойш нэг зуун наян (180) хоногийн хугацаанд ер (90)-ээс дээшгүй хоног визгүйгээр нэвтрэн орох, гарах, дамжин өнгөрөх болон зорчих эрхтэй бөгөөд тэдгээр нь Монгол Улсад хувиараа хөдөлмөр эрхлэх, эсхүл өөр аливаа бусад бизнесийн үйл ажиллагаа явуулах зэрэг аливаа хэлбэрийн хөдөлмөр эрхлэхийг хориглоно.

2 дугаар зүйл

1. Бүгд Найрамдах Эстони Улсад байгаа Монгол Улсын Дипломат болон консулын төлөөлөгчийн газарт гишүүнээр томилогдсон, эсхүл тус улс дахь олон улсын байгууллагад төлөөлөгчөөр ажиллахаар томилогдсон хүчин төгөлдөр цахим (биометрийн) дипломат паспорттой Монгол Улсын иргэд болон тэдгээрийн хамт амьдрах хүчин төгөлдөр цахим (биометрийн) дипломат паспорттой гэр бүлийн гишүүд нь Бүгд Найрамдах Эстони Улсад ер (90)-ээс дээшгүй хоногийн хугацаанд визгүйгээр нэвтрэн орох, зорчих буюу гарч болно. Энэхүү хугацааг Монгол Улсын Гадаад харилцааны яам, эсхүл Монгол Улсын Элчин сайдын яамнаас хүсэлт гаргаснаар тэдгээр иргэд ажил үүргээ гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаагаар сунгаж болно.

2. Монгол Улсад байгаа Бүгд Найрамдах Эстони Улсын Дипломат болон консулын төлөөлөгчийн газарт гишүүнээр томилогдсон, эсхүл тус улс дахь олон улсын байгууллагад төлөөлөгчөөр ажиллахаар томилогдсон хүчин төгөлдөр цахим (биометрийн) дипломат паспорттой Бүгд Найрамдах Эстони Улсын иргэд болон тэдгээрийн хамт амьдрах хүчин төгөлдөр цахим (биометрийн) дипломат паспорттой гэр бүлийн гишүүд нь Монгол Улсад ер (90)-ээс дээшгүй хоногийн хугацаанд визгүйгээр нэвтрэн орох, зорчих буюу гарч болно. Энэхүү хугацааг Бүгд Найрамдах Эстони Улсын Гадаад харилцааны яам, эсхүл Бүгд Найрамдах Эстони Улсын Элчин сайдын яамнаас хүсэлт гаргаснаар тэдгээр иргэд ажил үүргээ гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаагаар сунгаж болно.

3 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хүчин төгөлдөр цахим (биометрийн) дипломат паспорттой иргэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт ер (90)-ээс дээш хоногийн хугацаанд зорчих тохиолдолд урьдчилан виз авна.

4 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хүчин төгөлдөр цахим (биометрийн) дипломат паспорттой иргэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын олон улсын зорчилгоод нээлттэй хилийн боомтоор нэвтрэн орох, дамжин орох, эсхүл гарах бөгөөд тухайн Хэлэлцэн тохиролцогч талын шилжилт хөдөлгөөний тухай хууль тогтоомжийн дагуу бүх шаардлагатай журмыг мөрдөнө.

5 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хүчин төгөлдөр цахим (биометрийн) дипломат паспорттой иргэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт хилээр нэвтрэх болон зорчих хугацаандаа тухайн улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг хүндэтгэх үүрэгтэй.

6 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээр нь тааламжгүй гэж үзсэн цахим (биометрийн) дипломат паспорттой Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын иргэнийг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрэх, эсхүл зорчих хугацааг багасгах, эсхүл цуцлах Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллагын эрхийг хөндөхгүй.

7 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч тал бүр үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам, эсхүл олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор энэхүү хэлэлцээрийн үйлчилгээнийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн зогсоох эрхтэй. Ийм арга хэмжээ авах болон эргүүлэн цуцлах тухайгаа Хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа дипломат шугамаар урьдчилан мэдэгдэнэ.

8 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийн зорилгоор, Хэлэлцэн тохиролцогч талууд тус хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор цахим (биометрийн) дипломат паспортын загварыг дэлгэрэнгүй тайлбарын хамт дипломат шугамаар солилцоно.

Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал шинэ загварын цахим (биометрийн) дипломат паспорт нэвтрүүлэх, эсхүл өөрийн ашиглаж буй цахим (биометрийн) дипломат паспортод өөрчлөлт оруулах тохиолдолд тэрхүү шинэ загварын, эсхүл өөрчлөлт оруулсан цахим (биометрийн) паспорт хүчин төгөлдөр болох өдрөөс доод тал нь гуч (30) хоногийн өмнө уг паспортын загварыг дипломат шугамаар Хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа хүргүүлнэ.

9 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх, эсхүл тайлбарлахтай холбоотойгоор үүссэн аливаа маргааныг зөвшилцөх болон хэлэлцээ хийх замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

10 дугаар зүйл

1. Энэхүү хэлэлцээрийг хугацаагүйгээр байгуулсан болно. Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч талууд түүнийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа дипломат

шугамаар харилцан мэдэгдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Хэлэлцэн тохиролцогч талууд харилцан тохиролцож протокол байгуулах замаар энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Аливаа тийм нэмэлт, өөрчлөлт нь энэ зүйлийн 1 дэх заалтад дурдсан журмын дагуу хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү хэлэлцээрийг Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал цуцлах тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө талдаа зургаан (6) сарын өмнө дипломат шугамаар урьдчилан бичгээр мэдэгдэх замаар цуцалж болно.

Үүнийг нотлон, тус тусын Засгийн газраас зохих ёсоор эрх олгогдсон дор дурдсан төлөөлөгчид энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав.

Энэхүү хэлэлцээрийг Таллин хотноо 2014 оны 4 дүгээр сарын 28 -ны өдөр Монгол, эстони, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ ЭСТОНИ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ



MONGOOLOA VALITSUSE

JA

EESTI VABARIIGI VALITSUSE

BIOMEETRIILISTE DIPLOMAATILISTE PASSIDE KASUTAJATE SUHTES VIISANÕUDEST LOOBUMISE KOKKULEPE

Mongoolia valitsus ja Eesti Vabariigi valitsus, edaspidi *lepingupoole*,

juhindudes soovist edasi arendada kahe riigi sõbralikke suhteid;

soovides edendada, lihtsustada ja julgustada lepingupoole ametnike visiidite vahetust, vabastades biomeetriliste diplomaatiliste passide omanikud viisanõudest;

järgides mõlema riigi kehtivaid õigusakte;

on kokku leppinud järgmises.

Artikkel 1

1. Eesti Vabariigi kodanikele, kellel on kehtiv biomeetiline diplomaatiline pass, ei nõuta viisat Mongooliasse sisenedisel, sealt lahkumisel ega seal viibimisel kuni 90 päeva 180 päeva jooksul sisenedise päevast alates, eeldusel et nad ei asu Mongoolias tööle füüsilisest isikust ettevõtjana ega muus erateetvõttes.

2. Mongoolia kodanikele, kellel on kehtiv biomeetiline diplomaatiline pass, ei nõuta viisat Eesti Vabariiki sisenedisel, sealt lahkumisel, selle läbimisel ega seal viibimisel kuni 90 päeva 180 päeva jooksul sisenedise päevast alates, eeldusel et nad ei asu Eesti Vabariigis tööle füüsilisest isikust ettevõtjana ega muus erateetvõttes.

Artikkel 2

1. Eesti Vabariigi kodanikele, kellel on kehtiv biomeetiline diplomaatiline pass ning kes on Eesti Vabariigi diplomaatilise esinduse või konsulaarasutuse töötajad või

kes on Eesti Vabariigi esindajad rahvusvahelise organisatsiooni juures Mongoolias, ning nende perekonnaliikmeid, kellel on kehtiv Eesti Vabariigi biomeetiline diplomaatiline pass, ei nõuta viisat Mongooliasse sisenedisel, sealt lahkumisel ega seal viibimisel kuni 90 päeva. Eesti Vabariigi välisministeeriumi või suursaatkonna taotlusel võib seda aega pikendada kuni nende ametiaja lõpuni.

2. Mongoolia kodanikele, kellel on kehtiv biomeetiline diplomaatiline pass ning kes on Mongoolia Vabariigi diplomaatilise esinduse või konsulaarasutuse töötajad või kes on Mongoolia esindajad rahvusvahelise organisatsiooni juures Eesti Vabariigis, ning nende perekonnaliikmeid, kellel on kehtiv Mongoolia biomeetiline diplomaatiline pass, ei nõuta viisat Eesti Vabariiki sisenedisel, sealt lahkumisel ega seal viibimisel kuni 90 päeva. Mongoolia välisministeeriumi või suursaatkonna taotlusel võib seda aega pikendada kuni nende ametiaja lõpuni.

Artikkel 3

Lepingupoole kodanikud, kellel on lepingupoole kehtiv biomeetiline diplomaatiline pass ja kes soovivad viibida rohkem kui 90 päeva teise lepingupoole territooriumil, peavad eelnevalt taotlema viisa.

Artikkel 4

Lepingupoole kodanikud, kellel on lepingupoole kehtiv biomeetiline diplomaatiline pass, saavad teise lepingupoole territooriumile siseneda, sealt lahkuda või seda läbida mis tahes rahvusvahelise piirpunkti kaudu, täites vajalikke nõudeid kooskõlas teise lepingupoole siseriiklike kasitlevate õigusaktidega.

Artikkel 5

Lepingupoole kodanikud, kellel on lepingupoole kehtiv biomeetiline diplomaatiline pass, on kohustatud teise lepingupoole piiride ületamisel ja teise lepingupoole territooriumil viibimise ajal järgima õigusakte, mida kohaldatakse teise lepingupoole territooriumil.

Artikkel 6

Kokkuleppe ei piira lepingupoole pädevate asutuste õigust keelata riiki siseneda teise lepingupoole biomeetrilise diplomaatilise passi omanikele, keda peetakse etasoovitavaks, või lõpetada või lõpetada nende viibimise oma territooriumil.

Artikkel 7

Lepingupoolel võivad kokkuleppe täielikult või osaliselt peatada riikliku julgeoleku, avaliku korra või rahvatervise tagamiseks. Kokkuleppe peatamisest ja lõpetamisest teatatakse diplomaatilise kanalite kaudu teisele poolele viivitamata.

Artikkel 8

Kaesoleva kokkuleppe alusel edastavad lepingupooled üksteisele kehivate biomeetriliste diplomaatiliste passide näidised koos nende üksikasjaliku kirjeldusega diplomaatiliste kanalite kaudu 30 päeva jooksul pärast kokkuleppe allkirjastamist.

Lepingupooled teavitavad üksteist uutest või muudetud biomeetrilistest diplomaatilistest passidest ning edastavad passide näidised diplomaatiliste kanalite kaudu hiljemalt 30 päeva enne nende muutmist või kasutusele võtmist.

Artikkel 9

Kokkuleppe tõlgendamise või kohaldamisega seotud valdusi lahendavad lepingupooled konsultatsioonide või läbirääkimiste teel.

Artikkel 10

1. Kokkulepe on jõus määramata aja. Kokkulepe jõustub 30. päeval arvates päevast, mil saadakse diplomaatiliste kanalite kaudu kätte viimane teade lepingupoolte kokkuleppe jõustumiseks vajalike riigiseste nõuete täitmisest.

2. Kokkulepet võib muuta lepingupoolte kirjalikul nõusolekul eraldi seisva protokollina. Muudatus jõustub kaesoleva artikli lõike 1 kohaselt.

3. Mõlemad lepingupooled võivad kokkuleppe lõpetada, teatades sellest teisele poolte kirjalikult diplomaatiliste kanalite kaudu kuus kuud ette.

Selle kinnituseks on täievolilised isikud kokkuleppele alla kirjutanud.

Koostatud Tallinnas 28. aprillil 2014. kaheks eksemplariks mongoolia, eesti ja inglise keeles, kõik tekstid on võrdselt autentised. Tõlgendamis- või kohaldamisenõuete korral võetakse aluseks ingliskeelne tekst.

MONGOOLIA VALITSUS

EESTI VABARIIGI VALITSUS



AGREEMENT BETWEEN THE GOVERNMENT OF MONGOLIA AND THE GOVERNMENT OF THE REPUBLIC OF ESTONIA ON THE EXEMPTION OF VISA REQUIREMENTS FOR HOLDERS OF BIOMETRIC DIPLOMATIC PASSPORTS

The Government of Mongolia and the Government of the Republic of Estonia, hereinafter referred to as the "Contracting Parties",

Being guided by the desire to develop further friendly relations between the two States,

Desiring to promote, facilitate and encourage exchange of visits of officials of the Contracting Parties by the exemption of visa requirements for holders of their valid biometric diplomatic passports,

Pursuant to the applicable laws of both countries,
have agreed as follows:

Article 1

1. Holders of valid biometric diplomatic passports of Mongolia shall not be required to obtain a visa to enter, exit, transit through and stay in the Republic of Estonia for a period not exceeding ninety (90) days during a period of hundred and eighty (180) days from the date of their entry, provided that they do not take up any

employment in any form including self-employment, or any other business activity in the Republic of Estonia.

2. Holders of valid biometric diplomatic passports of the Republic of Estonia shall not be required to obtain a visa to enter, exit, transit through and stay in Mongolia for a period not exceeding ninety (90) days during a period of hundred and eighty (180) days from the date of their entry, provided that they do not take up any employment in any form including self-employment, or any other business activity in Mongolia.

Article 2

1. Holders of valid biometric diplomatic passports of Mongolia who are assigned as members of the diplomatic mission or consular post of Mongolia or who are representatives of Mongolia to an international organization in the Republic of Estonia, as well as their family members holding valid biometric diplomatic passports of Mongolia, may enter, stay and exit the Republic of Estonia without obtaining a visa for a period not exceeding ninety (90) days. Such period may, upon the request of the Ministry of Foreign Affairs of Mongolia or the Embassy of Mongolia, be extended until the end of their assignment.

2. Holders of valid biometric diplomatic passports of the Republic of Estonia who are assigned as members of the diplomatic mission or consular post of the Republic of Estonia or who are representatives of the Republic of Estonia to an international organization in Mongolia, as well as their family members holding valid biometric diplomatic passports of the Republic of Estonia, may enter, stay and exit Mongolia without obtaining a visa for a period not exceeding ninety (90) days. Such period may, upon the request of the Ministry of Foreign Affairs of the Republic of Estonia or the Embassy of the Republic of Estonia, be extended until the end of their assignment.

Article 3

Nationals of either Contracting Party holding valid biometric diplomatic passports of either Contracting Party, who wish to stay more than ninety (90) days in the territory of the other Contracting Party, shall obtain visa in advance.

Article 4

Nationals of either Contracting Party holding valid biometric diplomatic passports of either Contracting Party shall enter into, exit from or transit through ports open to international travelers of the other Contracting Party and follow all

necessary formalities in accordance with the immigration laws and regulations of that Contracting Party.

Article 5

Nationals of either Contracting Party holding valid biometric diplomatic passports of either Contracting Party are required to respect the laws and regulations applicable in the territory of the other Contracting Party while crossing the border and during their stay in the territory of the other Contracting Party.

Article 6

This Agreement does not restrict the right of the competent authorities of either Contracting Party to prohibit biometric diplomatic passport holders of the other Contracting Party who are considered undesirable from entering into or shorten or terminate their stay in its territory.

Article 7

Each Contracting Party may, for reason of ensuring national security, public order or public health, suspend this Agreement, either in whole or in part. The introduction and termination of such suspension shall be promptly notified in advance to the other Contracting Party through diplomatic channels.

Article 8

For the purposes of this Agreement, the Contracting Parties shall exchange through diplomatic channels the samples of their biometric diplomatic passports together with their detailed descriptions not later than thirty (30) days from the date of signing of this Agreement.

The Contracting Parties shall inform each other of an introduction of new biometric diplomatic passports or modification to existing biometric diplomatic passports, and shall transmit through diplomatic channels the samples of new or modified biometric diplomatic passports at least thirty (30) days prior to their introduction or validity of any modification.

Article 9

Any dispute arising out of implementation or application of this Agreement shall be settled by negotiation and consultation between the Contracting Parties.

Article 10

1. This Agreement has been concluded for an indefinite period of time. This Agreement shall enter into force thirty (30) days from the date of receipt of the last written notification by which the Contracting Parties notify each other, through diplomatic channels, of completion of their internal legal procedures required for entry into force of this Agreement.

2. This Agreement may be amended in writing by the mutual consent of the Contracting Parties in the form of a separate protocol. Any such amendment shall come into effect in accordance with paragraph 1 of this Article.

3. This Agreement may be terminated by either Contracting Party upon a six (6) months prior written notice given to the other Contracting Party through diplomatic channels.

IN WITNESS WHEREOF the undersigned, being duly authorized by their respective Governments, have signed this Agreement.

Done at Tallinn on 28 April 2014 in two original copies, in the Mongolian, Estonian and English languages, all texts being equally authentic. In case of divergences in interpretation, the English text shall prevail.

FOR THE GOVERNMENT
OF MONGOLIA



FOR THE GOVERNMENT OF
THE REPUBLIC OF ESTONIA



